Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2026 оны 01 дүгээр сарын
08-ны өдрийн албан бичгийн хавсралт
3/33

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0.8	9
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0.5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	3.8	38
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.8	9
Хэсгийн оноо				**3**	2.8	28
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	0.8	8
Хэсгийн оноо				**3**	2.8	28
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9.4**	**94**

БАТЛАВ
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА С.ДЭЛГЭРНОМИН

УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хамрах хүрээ	Хариуцагч	Төсөв	Хүрэх үр дүн
Нэг. Ёс зүйн дэд хорооны гүйцэтгэх ажил						
1	Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах	I улиралд	АЗДТГ, харьяа албан байгууллагууд	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	-	Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг батлуулсан байна.
2	Аймгийн ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдын ёс зүйн дүрэм боловсруулж, батлуулах	I улиралд	Нийт албан хаагчдад	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	-	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд Ёс зүйн дүрмийг боловсруулж, батлуулсан байна.
3	Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг боловсруулан батлуулах	I улиралд	-	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд		Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг боловсруулан, журмын дагуу ажилласан байна.
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж, ёс зүйн хороонд хүргүүлэх	Тухай бүр	Нийт албан хаагчдад	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	-	ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооны тайланг цаг тухайд нь хүргүүлсэн байна.
5	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан, шалгаж дүгнэлт гаргах	Тухай бүр	-	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	-	Ёс зүйн хороонд ирсэн гомдол мэдээллийг хууль тогтоомжийн дагуу хянан шалгаж шийдвэрлэсэн байна.
6	Увс аймгийн түүхт 100 жилийн ойд ТАХ-дыг татан оролцуулах, оролцоог хангах чиглэлээр нөлөөллийн ажил хийх	II-III улиралд	Нийт албан хаагчдад	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд		Увс аймгийн 100 жилийн ойд төрийн албан хаагчдыг татан оролцуулахад нөлөө үзүүлсэн байна.
7	Байгууллагын ёс зүйн орчин	IV улиралд	Нийт албан	Ёс зүйн дэд		Байгууллагын ёс зүйн

	нөхцөлд дүн шинжилгээ хийх, 2026 оны ажлын төлөвлөгөөний санал боловсруулах		хаагчдад	хорооны дарга, гишүүд		орчин нөхцөлд дүн шинжилгээ хийж, 2026 оны ажлын төлөвлөгөөний санал боловсруулсан байна.
Хоёр. Албан хаагчдад ёс зүй, харилцаа хандлагын сургалт зохион байгуулах						
1	Ёс зүйн 7 хоногийг зохион байгуулах	II улиралд	Нийт албан хаагчдад	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	-	Ёс зүйг дээдэлсэн, шударга ажиллах орчныг бүрдүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг байгууллага болон нэгжийн түвшинд зохион байгуулах чадвар эзэмшинэ.
2	“Сэтгэлгээний өөрчлөлт” сургалтыг АЗДТГ-ын албан хаагчдад зохион байгуулах	II улиралд	Нийт албан хаагчдад	А.Золзаяа Г.Энхтуяа	-	
3	Авилга, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр	III улиралд	Нийт албан хаагчдад	Э.Наранмандах	-	
Гурав. Бусад байгууллага, агентлагуудад сургалт хийх, зөвлөмж өгөх						
1	Салбарын болон байгууллагын хүрээнд үйлчлэх хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм, журмуудыг танилцуулах, сурталчлах	II улиралд	Нийт албан хаагчдад	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	-	Авилга, ашиг сонирхлын тухай ойлголт, илрэх хэлбэрүүд, урьдчилсан сэргийлэх арга хэрэгсэл, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай онолын мэдлэг, ойлголттой болж, түүнийг практик үйл ажилагаанд хэрэгжүүлнэ.
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн, авилга, ашиг сонирхлын зөрчил сэдвээр сургалт зохион байгуулах	I-IV улиралд	Нийт албан хаагчдад	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	-	

Тайлбар: Ёс зүйн сургалтын хугацаа давтамж Ажлын байрын сургалт 14 хоногт 1 удаа 20 минутаас хэтрэхгүй, хэлтэс, баг, хамт олонд 10 хоногт 1 удаа 10 минутаас хэтрэхгүй. Ажлын байрнаас гадуурх болон танхимын сургалт – улиралд 1 удаа, 1 цагаас хэтрүүлэхгүй хийнэ.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.ЭНХТУЯА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2026 оны 01 дүгээр сарын
08-ны өдрийн албан бичгийн хавсралт
3/33

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга[1]
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд нийцүүлэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн захиргааны байгууллага, сумын Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 44 төрийн захиргааны байгууллага Ёс зүйн дэд хороо байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо нь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/75 тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулагдсан. 2025 оны Ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаа. Тус онд Ёс зүйн дэд хороонд 3 өргөдөл, гомдол ирсэн ба ёс зүйн зөрчил болох нь тогтоогдоогүй тул буцааж иргэнд хариу хүргүүлэн ажиллаа.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:
2025 онд Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд соён гэгээрүүлэх болон нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын тасралтгүй суралцах, орон зай цаг хугацаанаас үл хамааран чадавх, ур чадвараа тогтмол дээшлүүлэх таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг 122 сэдэв, арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулж үе шаттайгаар зохион байгуулан ажиллаа. **Онцолвол дараах үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.** ✓ АЗДТГ-ын Санхүү төрийн хэлтэс “Төрийн сангийн системд олон улсын IBAN дансны нэгдсэн дугаарлалтын нэвтрүүлэлт, Төрийн сангийн шинэчлэгдсэн

заавар, журам цаашид анхаарах асуудал" сэдэвт сургалтыг Сумдын санхүү албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдэд,

- ✓ Дэлхийн зөн төсөл хөтөбөр хариуцагчдаас "Дэлхийн зөн ОУБ-н Хөгжлийн хөтөлбөрийн аргачлалыг танилцуулах" сургалтыг аймгийн төрийн удирдлага, ТББ, ИНБ,
- ✓ АЗДТГ-аас "Төрийн ажлын зохион байгуулалт сайжруулах" сургалтыг Сумдын ЗД, ЗДТГ-ын дарга нарт,
- ✓ "Боловсролын салбарт баримтлах бодлого, чиглэл авч хэрэгжүүлэх арга" сургалтыг бүх Боловсролын байгууллагын удирдлагуудад,
- ✓ "Тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах,
- ✓ Хууль, тогтоомж стандартыг сурталчлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөөн"-г согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэгч нарт,
- ✓ Сумдын хууль эрх зүй, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүдэд "Арга зүйн зөвлөгөө өгөх сургалт, хэлэлцүүлэг"
- ✓ "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал сургалт хэлэлцүүлэг,
- ✓ Увс аймгийн Гэр бүлийн чуулган, хэлэлцүүлэг,
- ✓ Аюулгүй байдал батлан хамгаалах асуудал,
- ✓ Нийтийн хоолны стандарт эрүүд ахуйг сайжруулах зэрэг танхимын сургалтуудыг тус тус холбогдох хэлтсээс зохион байгуулсан байна.
- ✓ УА-ийн багш нарын бүрэлдэхүүнийг орон нутагт урьж "Дизайн сэтгэлгээ" сэдэвт 2 өдрийн сургалтыг байгууллагын төлөөлөл 46 албан хаагчид зохион байгуулсан.
- ✓ Аймгийн хэмжээний нийт төрийн албан хаагчдын төлөөллөөс бүрдсэн 500 төрийн албан хаагчийн "Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба зөвлөгөөн"-г зохион байгуулсан.
- ✓ УА-ийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 10, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 5, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 22, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 7 албан хаагч нийт 44 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад цахимаар хамруулсан байна.

- ✓ "Төрийн хаагчийн ёс зүйн тухай хууль болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалтыг Давст сумын ЗДТГ, Онцгой байдлын газар, Улаангом сумын Соёлын төв, 9 дүгээр цэцэрлэг, "Ойрад" хөгжимт жүжгийн театр, Түргэн, Сагил сумдад тус тус зохион байгууллаа.
- ✓ Төрийн албаны удирдлагын манлайлал, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах хүрээнд аймгийн Засаг дарга, бүх сумдын Засаг дарга, агентлагийн дарга нартай 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр "Хуульд заасан зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх гэрээ байгуулж, батламж гардуулсан.
- ✓ Ховд аймагт зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал" бүсийн зөвлөгөөнд АЗДТГ, төрийн байгууллага, 19 сумын ЗДТГ-ын нийт 105 албан хаагчийг тус тус хамруулсан.
- ✓ ТАСЗ, АЗДТГ-аас төрийн байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд ёс зүйн тухай хуулийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Түүнчлэн бүх төрийн байгууллага сумдад "Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг чангатгах тухай" аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний 05 дугаар албан даалгаврыг хүргэж биелэлтийг улирал бүр нэгтгэж, хянан ажиллаа. Мөн 2025 оны 04 дүгээр сараас "**Канад-Монголын хамтарсан Мерит төсөл**" манай аймагт хэрэгжиж төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, тасралтгүй чадавхжих, үйл ажиллагааг тогтмолжуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үүний хүрээнд:

- ✓ Хүний нөөцийн клуб
- ✓ Жендэрийн клубыг нээж гишүүд тогтмол уулзалт зохион байгуулан сургалт, нөлөөлийн ажлыг хийхээр 2026 оны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын үйлчилгээ иргэдэд хурдан шуурхай, ил тод нээлттэй хүрч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор иргэдээс "**Сэтгэл ханамжийн судалгаа**" авч нэгтгэн, дүгнэлт гарган холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна. Үүний нэг ажил нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 19 сая төгрөгийг шийдвэрлэн **"Онч шийдэл ТББ"-аар** аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт **"Авлигын эрсдлийн үнэлгээ"** хийлгэж

тайлангийн дагуу ажил сайжруулах чиглэлийг тухайн байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Аймгийн хэмжээнд ирсэн 10 өргөдөл, гомдолд Ёс зүйн дэд хорооноос дүгнэлтээр зөрчил гаргасан гэж үзэж, томилох эр бүхий албан тушаалтнаас дүгнэлтийг үндэслэн арга хэмжээ тооцож ажилласан. Мөн 49 албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулж, арга хэмжээ авсан байна. Аймаг хэмжээнд сум, байгууллагууд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдээ, мэдээлэл, хэрэгжилтийн тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг тухай бүрт цахим хуудсанд байршуулж хэвшсэн. Мөн ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд бүртгүүлэн, үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөг тухай бүр шинэчлэн ажиллаж байна. 2025 онд 19 сумын Засаг даргын Тамгын газар, 25 агентлаг байгууллагад ёс дэд хороо шинэчлэн байгуулагдсан бөгөөд үйл ажиллагааны үр дүнг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтын шийдвэрээр улирал тутам урамшуулал олгож байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Сум, байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн төлөөллийг ТАЗ-өөс зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил–Төрийн албаны манлайлал” сэдэвт бүсийн зөвлөгөөн, Увс аймгийн ТАЗ-өөс зохион байгуулсан “Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба зөвлөгөөн”-д хамруулж, төрийн албан хаагчийн хууль тогтоомжийн хэрэглээн, ёс зүйн манлайллын чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын дэргэдэх ёс зүйн дэд хорооноос сум, байгууллагын ёс зүйн дэд хороог мэдээлэл, аргазүйгээр ханган ажилладаг. Энэ хүрээнд сумдын болон байгууллагын ёс зүйн дэд хороод шинэчлэн байгуулагдаж, төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд бүртгүүлэн, үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөг тухай бүр шинэчлэн ажиллаж байна. 2025 онд 19 сумын Засаг даргын Тамгын газар, 25 агентлаг байгууллагын хэмжээнд иргэдэд үзүүлэх төрийн үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн ёс

зүйтэй холбоотой 47 өргөдөл, гомдол ирснээс 5 гомдлыг зөрчил гаргасан гэж тогтоож холбогдох байгууллагын ёс зүйн дэд хороод нь дүгнэлт гаргасан.

Аймгийн хэмжээний төрийн байгууллагуудаас томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр 49 албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулж, арга хэмжээ авсан.

Сум, байгууллагын ёс зүйн дэд хорооноос төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 42 гаруй сургалт, 31 нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулснаар төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан. Иргэд төрийн үйлчилгээний чанар хүртээмжинд сэтгэл ханамж нэмэгдсэн.	• Ёс зүйн дэд хорооны гишүүдийн өргөдөл гомдол шийдвэрлэх мэдлэг, ур чадвар дутмаг. • Хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа хангалтгүй, үр дүн багатай.

Санал:

- ✓ Аймгийн хэмжээний Ёс зүйн дэд хороодыг удирдан чиглүүлэх, дээд шатанд гаргах өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, тайлан мэдээг нэгтгэж, удирдлага арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий “Аймгийн ерөнхий ёс зүйн хороо” байгуулах хууль эрх зүйн орчныг бий болгох
- ✓ Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас байгууллагуудын “Ёс зүйн дэд хорооны гишүүд”-ийг мэдлэг, арга зүйгээр хангах, чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг танхимын болон цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулах, сертификат олгох, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх процессын ажиллагаанд дадлагажуулах
- ✓ Ёс зүйн чиглэлээр орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

АЗДТГ-ын дарга ..... (У.Ганзориг)

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

Салбарын хяналт,
зохицуулалтын хэлтсийн дарга ..... (С.Дэлгэрномин)

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ТЗУХ-ийн мэргэжилтэн ..... (Г.Энхтуяа)

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр